



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2020 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А - 426

Улаанбаатар хот

Долоо хоногоос урт хугацаатай репо арилжааны нэмэлт нөхцөл батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн дугаар тушаалаар батлагдсан Репо арилжааны журмын 2.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Жижиг дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарт олгосон төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар 2 жилийн хугацаатай репо арилжаа хийхийг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин)-т даалгасугай.

2. Энэ тушаалын 1 дэх заалтад заасан репо арилжааг Мөнгөний бодлогын хорооноос тогтоосон хэмжээнд багтаан Репо арилжааны журмын 2.2.2 дахь заалтад заасан хэлбэрээр арилжаалсугай.

3. Энэ тушаалын 1 дэх заалтад дурдсан үнэт цаасжуулах зээлийн багц болон репо арилжаагаар авсан эх үүсвэрээр банк шинээр зээл олгох, олгосон зээлийн нөхцөлд өөрчлөлт оруулахад тавигдах шаардлагыг энэ тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсугай.

4. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар (А.Энхжин), Санхүү бүртгэлийн газар (Ц.Гарьд), Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газар (Н.Ариунбат), Хяналт, шалгалтын газар (Ц.Нарандалай)-т тус тус даалгасугай.


5. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын газар (Т.Амарсайхан)-т даалгасугай.

6. Энэ тушаалыг 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН



**ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ЗЭЭЛИЙН БАГЦ БОЛОН РЕПО АРИЛЖААГААР АВСАН
ЭХ ҮҮСВЭРЭЭР ШИНЭЭР ЗЭЭЛ ОЛГОХ, ОЛГОСОН ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

№	ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ	ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫН САЛБАР
1	Зээлийн ангилал	Зээлийн хугацаанд ангилал буураагүй аж ахуйн нэгжийн төгрөгийн зээл байх (Хэвийн зээл)	Зээлийн хугацаанд ангилал буураагүй аж ахуйн нэгжийн төгрөгийн зээл байх (Хэвийн зээл)
2	Зээлийн үлдсэн хугацаа	2 жилээс доошгүй байна	2 жилээс доошгүй байна
3	Үнэт цаасжуулах зээлийн дээд хэмжээ	300 сая төгрөг хүртэл	1 тэрбум төгрөг хүртэл
4	Шинээр олгох зээл, дахин санхүүжүүлэх зээлийн харьцаа	70 хувийг шинэ зээлд, 30 хувийг дахин санхүүжүүлэхэд ашиглана	70 хувийг шинэ зээлд, 30 хувийг дахин санхүүжүүлэхэд ашиглана
5	Шинээр олгох, дахин санхүүжүүлэх зээлийн хүү	Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна	Репо арилжааны хүү +4 нэгж хувиас хэтрэхгүй байна
6	Үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа	6 сараас доошгүй байна	6 сараас доошгүй байна
7	Зээлийг урьдчилан төлж болох эсэх	Болно	Болно
8	Зээлдэгчтэй холбоотой хуулийн хариуцлага хүлээсэн эсэх	Хүлээгээгүй	Хүлээгээгүй
9	ААН-ийн зээлийн тогтмол төлбөр төлөх боломж ¹	Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх	Сарын EBITDA (Хүү, татвар, элэгдэл, хорогдлын өмнөх орлого) нь зээлийн нэг удаагийн эргэн төлөлтөөс /сараар эргэн төлөлт хийгддэг бол/ багагүй байх
10	Үйл ажиллагааны тогтвортой байдал	Сүүлийн 6 сар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх	Сүүлийн 6 сар тасралтгүй үйл ажиллагаа эрхэлсэн байх
11	Барьцаа хөрөнгийн төрөл	Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө	Үл хөдлөх ба хөдлөх хөрөнгө
12	Барьцаа хөрөнгийн шалгуур	(i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх; (ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн шилжих боломжтой байх); (iii) Барьцаа хөрөнгө нь үнэт	(i) Банкны шаардлагыг хангасан өөрийн өмчлөлийн эсвэл гуравдагч этгээдийн барьцааны зүйл байх; (ii) Барьцаа хөрөнгө нь шаардах эрхийн зөрчилгүй (ТЗК-руу шаардах эрх нь бүрэн

¹ 2019 оны сүүлийн байдлаар

№	ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ	ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАР	УУЛ УУРХАЙН БУС ЭКСПОРТЫН САЛБАР
		<p>цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжинд барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна;</p> <p>(v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх;</p> <p>(vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна</p>	<p>шилжих боломжтой байх);</p> <p>(iii) Барьцаа хөрөнгө нь үнэт цаасны багцад багтаж байгаа хэвийн зээлээс өөр хэвийн зээлд давхар харьяалагдаж болно. Уг тохиолдолд зээл чанаргүй ангилагдсан тохиолдолд үнэт цаасанд харьяалагдах зээлийн төлбөрийг тухайн аж ахуйн нэгж тэргүүн ээлжинд барагдуулахыг хүлээн зөвшөөрсөн байна;</p> <p>(v) Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэт цаасжуулалт хийгдэхээс 6 сараас багагүй хугацааны өмнө хийсэн байх;</p> <p>(vi) Хөдлөх эд хөрөнгө барьцаалж буй тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан барьцаа хөрөнгө байна</p>
13	Зээл үнэлгээний харьцаа	Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх	Зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 70 хувиас ихгүй байх
14	Санхүүгийн тайлангийн шалгуур	МУ-ын засгийн газрын 113-р тогтоолын 5.9.7-д ЖДҮ-ийн сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс)	Сүүлийн 2 жилийн баталгаажсан тайлан байх (Хэрэв 2 жилийн дотор байгуулагдсан бол байгуулагдсанаас хойших санхүүгийн баталгаажсан тайлан, шинээр үүсгэн байгуулагдсан бол эхлэлтийн баланс)
15	Бусад	<p>(i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх;</p> <p>(ii) Зээлдэгчтэй хамаарал бүхий этгээд нь чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх</p>	<p>(i) Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлдэг байх;</p> <p>(ii) Зээлдэгчтэй хамаарал бүхий этгээд нь чанаргүй зээлийн үлдэгдэлгүй байх</p>